БАТЛАВ.
СОЁЛЫН ӨВИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН
ЗАХИРАЛ Г.ЭНХБАТ

2026 оны 02 дугаар сарын 10

# БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙХ ДОТООД ХЯНАЛТ, ШАЛГАЛТЫН 2026 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

2026 оны 02 дугаар сарын 10 Улаанбаатар хот

| Д/д | | Хяналт, шалгалт хийх арга хэмжээ | Шалгуур үзүүлэлт | Хүрэх үр дүн | Хугацаа | Хамтран хэрэгжүүлэх албан тушаалтан |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | | 5 | 6 |
| **НЭГ. ЗАХИРГАА УДИРДЛАГА, ДОТООД АЖЛЫН ҮР ДҮНГ САЙЖРУУЛАХ ЧИГЛЭЛЭЭР** | | | | | | |
| 1. | 1.1. | Захиргааны зөвлөлийн хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтэд хяналт-шинжилгээ үнэлгээ хийх. | - Өгсөн үүрэг даалгаврын тоо.<br>- Биелсэн үүрэг даалгаврын тоо.<br>- Биелээгүй үүрэг даалгаврын тоо. | Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг тогтоосон хугацаанд тайлагнаж, биелэлтийн хувь өснө. | Хагас, бүтэн жилээр | Бичиг хэргийн эрхлэгч, Захиргааны мэргэжилтэн |
| | 1.2. | Албан хэрэг хөтлөлтөд хариутай албан бичиг болон өргөдөл, гомдлын шийдвэрлэлт, албан хэрэг хөтлөлтийг бүрэн цахимжуулахад erp.e-mongolia.mn программын ашиглалтад хяналт тавих. | - Ирсэн албан бичгийн тоо.<br>- Хугацаанд нь шийдвэрлэсэн албан бичгийн тоо.<br>- Хугацаа хоцорсон албан бичгийн тоо.<br>- Албан хэрэг хөтлөлтийн цахимжсан хувь. | Хариутай болон хариугүй бичгийн шийдвэрлэлтэд хугацаа хэтрүүлэхгүй байх, албан хэрэг хөтлөлтийн чанар дээшилнэ. | Хагас, бүтэн жилээр | Бичиг хэргийн эрхлэгч |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | 1.3. | Нээлттэй мэдээллийн систем (shilen.gov.mn)-д "шилэн индекс"-ийн тайланд хяналт тавих, хангалтгүй үнэлгээтэй мэдээллийн шалтгаан нөхцөлийг тодорхойлж, холбогдох арга хэмжээ авах. | - Нээлттэй мэдээллийн ил тод байдлын үнэлгээний хувь.<br>- Үнэлгээ өсгөх шаардлагатай асуулгын тоо.<br>- Үнэлгээ өсгөхөд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо. | Байгууллагын үнэлгээний хувь өсөж, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилт бүрэн хангагдана. | Улирал бүр | Дотоод ажил хариуцсан мэргэжилтэн |
| | 1.4. | Байгууллагын 2025 оны санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг үндэслэн илрүүлсэн алдаа, зөрчлийг арилгах арга хэмжээний биелэлтэд хяналт тавих. | - Зөрчлийн тоо.<br>- Зөрчлийг арилгахад авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо. | 2025 оны санхүүгийн тайлангийн аудитаар илрүүлсэн алдаа, зөрчлийг арилгаж, цаашид алдаа, зөрчилгүй ажиллана. | Хагас жилээр | Ерөнхий нягтлан бодогч<br>Тооцооны нягтлан бодогч<br>Нярав |
| | 1.5. | Байгууллагын 2025-2028 онд хэрэгжүүлэх Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр болон сургалтын хөтөлбөрийн 2026 оны төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавих, эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээг тодорхойлох. | - Хэрэгжилтийн хувь.<br>- Хэрэгжилтийн чанар.<br>- Эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээний тоо. | Албан хаагчдын сурч, хөгжих боломжийг бүрдүүлэх, дэмжлэг үзүүлэх, албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, эрүүл амьдрах дадлыг хэвшүүлэх, албан хаагчийн нийгмийн хэрэгцээ, ажиллах орчин, нөхцөлийг дээшлүүлэх, сэтгэл зүйн хандлагыг мэдэрч, байгууллагын соёл, хамт олны уур амьсгалыг өөрчлөх замаар албан хаагчдын ажлын байр дээрх сэтгэл ханамжийг сайжруулна. | Хагас, бүтэн жилээр | Хүний нөөцийн ажилтан |
| | 1.6. | Албан хаагчдын хос бичгээр албан хэрэг хөтлөлтөд хяналт тавих. | - Монгол бичиг сайн мэддэг албан хаагчийн тоо. | Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана. | Хагас, бүтэн жилээр | Бичиг хэргийн эрхлэгч |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | - Монгол бичгийн мэдлэгийг сайжруулах шаардлагатай албан хаагчийн тоо.<br>- Анхан шатны сургалтад хамрагдах шаардлагатай албан хаагчийн тоо. | | | |
| | 1.7 | Гэрээт харуул хамгаалалтын үйлчилгээний чанар аюулгүй байдалд хяналт тавих, гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтийг хангуулж ажиллах. | - Сайжруулах шаардлагатай арга хэмжээний тоо.<br>- Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо. | Гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлт хангагдаж, харуул хамгаалалтын үйлчилгээнд гарах эрсдэлээс урьдчилан сэргийлнэ. | Хагас, бүтэн жилээр | Зохион байгуулагч |
| | | **ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТЭД ЯВУУЛАХ ДОТООД ХЯНАЛТ** | | | | |
| 2. | 2.1. | Байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтэд хагас, бүтэн жилээр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх. | - Арга хэмжээний үнэлгээний хувь.<br>- Эрчимжүүлэх арга хэмжээний тоо. | Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн сайжирч тайлангийн чанар дээшилнэ. | Хагас, бүтэн жилээр | Захиргааны мэргэжилтэн |
| | 2.2. | ХАБЭА-н талаар хэрэгжүүлж буй арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавьж, хариуцсан албан хаагчтай хамтран ажиллах. | - Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо.<br>- Хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний тоо. | ХАБЭА-н тухай хууль болон холбогдох дүрэм журмын биелэлтийг ханган осолгүй ажлын байрыг бий болгоно. | Жилээр | ХАБЭА хариуцсан ажилтан |
| | 2.3. | Байгууллагын дүрэм болон газар нэгжийн дотоод журам, бусад соёлын өвтэй холбогдох журмаар хүлээсэн үүрэг болон дээд газраас ирүүлсэн тушаал, тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх. | - Байгууллагын дотоод дүрмээр хүлээсэн үүргийн биелэлтийн тоо.<br>- Газар нэгжийн дотоод журмаар хүлээсэн үүргийн биелэлтийн тоо.<br>- Соёлын өвтэй холбоотой дүрэм, журмаар хүлээсэн үүргийн биелэлтийн тоо. | Үндэсний төвийн захирлын 2024 оны А/15 тушаалаар батлагдсан "Дотоод хяналт, шалгалтыг зохион байгуулах журам"-ын хэрэгжилт бүрэн хангагдана. | Хагас, бүтэн жилээр | Ерөнхий бүртгэл, мэдээллийн санч<br>Ерөнхий сэргээн засварлагч<br>Ерөнхий технологич<br>Захиргааны мэргэжилтэн |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | | - Дээд газраас ирүүлсэн тогтоол шийдвэрийн тоо.<br>- Дээд газраас ирүүлсэн тогтоол шийдвэрийн биелэлтийн хувь. | | | |
| | 2.4. | Байгууламжийн үйл ажиллагаа, цахилгаан хангамж, аюулгүй байдалд үзлэг шалгалт явуулж, удирдлагыг мэдээллээр хангах, холбогдох арга хэмжээ авах. | - Илэрсэн зөрчлийн тоо.<br>- Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо.<br>- Шаардлагатай төсөв. | Үндэсний Их баяр наадам болон бусад бүх нийтээр амрах баярын болон тэмдэглэлт өдрүүдэд хариуцлагатай жижүүр байнга ажиллуулах, барилга байгууламжийн дэд бүтцийн аюулгүй байдлыг хангаж ажиллана. | Хагас, бүтэн жилээр | Зохион байгуулагч |

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, УДИРДЛАГЫН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Г.АНХСАНАА

БОЛОВСРУУЛСАН:

ЗАХИРГААНЫ МЭРГЭЖИЛТЭН Д.ТҮВШИНДЭЛГЭР